



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/364

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг алхалт, гүйлтээр хичээллүүлэх замаар нийгмийн идэвхтэй иргэн болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготойгоор Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж буй “Багачуудын хөгжилтэй гүйлт-Ховд 2025” арга хэмжээний зардалд 15,350,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд зарцуулах 15,350,000 (арван таван сая гурван зуун тавин мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 5.6-д тусгагдсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсөл арга хэмжээний зардлаас тооцож гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Анхбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Баярт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 1117

Zah A/364 Kh

Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 13-ны өдрийн
А/364 дүгээр захирамжийн хавсралт

№	Зардлын нэр, төрөл		Тоо ширхэг, хэмжээ	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Нийт дүн (төгрөгөөр)
1	Анонс		1	600,000	600,000
2	Медаль		60	20,000	1,200,000
3	Сертификат		60	2,000	120,000
4	Энгэрийн дугаар		550	2,000	1,100,000
5	Асарны хаяг, бусад хулдаасан хэвлэл		8	40,000	320,000
6	ХБ хүүхдүүдийн шорт футболка		50	25,000	1,250,000
7	6-8 насны шагнал	1-р байр	4	50,000	200,000
		2-р байр	4	30,000	120,000
		3-р байр	4	20,000	80,000
8	9-11 насны шагнал	1-р байр	4	50,000	200,000
		2-р байр	4	30,000	120,000
		3-р байр	4	20,000	80,000
9	11-15 насны шагнал	1-р байр	4	50,000	200,000
		2-р байр	4	30,000	120,000
		3-р байр	4	20,000	80,000
10	9-11 насны шагнал	1-р байр	4	50,000	200,000
		2-р байр	4	30,000	120,000
		3-р байр	4	20,000	80,000
11	11-15 насны шагнал	1-р байр	4	50,000	200,000
		2-р байр	4	30,000	120,000
		3-р байр	4	20,000	80,000
12	Цуглуулсан зайн урамшуулал		4	50,000	200,000
13	Хотоос ирэх багийн буудал, хоол		15*3	60,000	2,700,000
14	Хотоос ирэх багийн унааны зардал		15*2	224,000	3,360,000
Нийт дүн					15,350,000

-oOo-